



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/84

Мандалговь

“Од Эс Эс” ХХК-тай гэрээ  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр оруулалтаар “Хулд суманд Эрэн хайх, аврах бүлгийг шинээр байгуулахад шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нийлүүлэх” ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Од Эс Эс” ХХК-тай 100,595,070 (нэг зуун сая таван зуун ерэн таван мянга дал) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2.Батлагдсан техникийн үзүүлэлтийн дагуу “Хулд суманд Эрэн хайх, аврах бүлгийг шинээр байгуулахад шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нийлүүлэх” ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Од Эс Эс” ХХК-ны захирал (Д.Чогсомжав)-д үүрэг болгосугай.

3.Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Хулд сумын Засаг дарга (П.Бямбалхавга), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

4822150190